



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/261-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13-14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14-15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	16-17
3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17-18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭУСАХЗ	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
НА	Нотлох ажил
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОБГ	Онцгой байдлын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.22 № СЭА-2022/261-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,948,957.50	232,427,519.84
34	УРЬДЧИЛГАА	0.00	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	109,948,957.50	225,227,519.84
35100	Түүхий эд материал	0.00	128,692,718.54
35130	Эм боох материал	0.00	128,692,718.54
35400	Хангамжийн материал	109,948,957.50	96,534,801.30
35410	Бичиг хэргийн материал	670,300.00	1,507,400.00
35420	Аж ахуйн материал	1,670,090.00	1,032,642.50
35440	Түлш, шатах тослох материал	1,733,100.00	4,013,900.00
35470	Бусад хангамжийн материал	105,875,467.50	89,980,858.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	573,747,780.00	1,676,821,275.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	573,747,780.00	1,676,821,275.96
39200	Биет хөрөнгө	477,722,446.74	1,581,251,942.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	56,613,718.93	56,613,718.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,006,187.80	-18,386,375.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	198,690,372.52	165,931,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,388,565.96	-58,752,653.44
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	389,963,623.70	1,450,130,281.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-227,778,264.52	-157,101,390.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	195,588,101.35	171,403,548.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,960,351.48	-28,586,486.61
39300	Биет бус хөрөнгө	96,025,333.26	95,569,333.26
39301	Програм хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-382,666.74	-838,666.74
39303	Бусад биет бус хөрөнгө	94,128,000.00	94,128,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	683,696,737.50	1,909,248,795.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	156,194.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	156,194.32
41300	Өглөг	0.00	156,194.32
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	156,194.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	683,696,737.50	1,909,092,601.48
51	Засгийн газрын хувь оролцоо	683,696,737.50	1,909,092,601.48
51200	Хуримтлагдсан үр дүн	683,696,737.50	1,909,092,601.48
51210	Өмнөх үеийн үр дүн	257,526,384.45	683,696,737.50
51220	Тайлант үеийн үр дүн	426,170,353.05	1,225,395,863.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	683,696,737.50	1,909,248,795.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,627,111,830.15	3,526,806,129.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	598,729,108.31	2,263,567,668.34
120	Нийтлэг татварын бус орлого	598,729,108.31	2,263,567,668.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,418,500.00	4,921,140.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,418,500.00	4,921,140.00

Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	434,373,130.03	1,275,215,424.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	160,937,478.28	983,431,103.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,028,382,721.84	1,263,238,461.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	588,717,500.00	817,560,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	588,717,500.00	817,560,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	439,665,221.84	445,678,361.12
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	319,999,721.84	407,974,311.12
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,479,100.00	37,704,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,186,400.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,200,941,477.10	2,301,410,265.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,941,477.10	2,301,410,265.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,182,054,394.36	2,214,878,646.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,324,100.00	442,385,605.51
210101	Үндсэн цалин	74,928,300.00	331,322,235.23
210102	Нэмэгдэл	25,435,800.00	95,413,498.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,960,000.00	15,649,871.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,083,800.00	61,498,964.41
210201	Тэтгэврийн даатгал	9,910,800.00	40,099,918.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,043,300.00	4,468,165.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	834,600.00	8,027,576.36
210204	Ажилгүйдлийн даатгал	208,600.00	809,391.81
210205	Эрүүл мэндийн даатгал	2,086,500.00	8,093,912.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,472,171.94	17,270,494.32
210301	Гэрэл, цахилгаан	4,637,100.00	5,092,994.32
210302	Түлш, халаалт	10,835,071.94	12,177,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,155,524.18	45,827,895.00
210401	Бичиг хэрэг	7,034,800.00	2,584,600.00
210402	Тээвэр, шатахуун	28,655,875.96	36,813,795.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,519,587.22	4,392,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,945,261.00	2,037,100.00
2105	Нормативт зардал	239,999,890.59	941,480,252.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	239,844,890.59	941,000,252.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	155,000.00	480,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,528,600.00	6,730,000.00

210604	Урсгал засвар	2,528,600.00	6,730,000.00
2107	Томилолт, зочны зардал	20,945,500.00	17,018,300.00
210702	Дотоод албан томилолт	20,945,500.00	17,018,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652,078,147.08	393,934,160.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	649,514,724.08	388,896,779.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	409,562.00	573,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,570.00	357,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	319,000.00	341,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	921,291.00	165,561.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,466,660.57	288,732,974.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,420,957.45	112,741,045.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,045,703.12	175,991,928.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,887,082.74	86,531,619.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,879,600.00	3,660,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,877,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,002,400.00	3,660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,007,482.74	82,871,619.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,007,482.74	82,871,619.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	426,170,353.05	1,225,395,863.98
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	426,170,353.05	1,225,395,863.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,034,819,682.00	1,268,159,601.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,418,500.00	4,921,140.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,418,500.00	4,921,140.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,418,500.00	4,921,140.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,418,500.00	4,921,140.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,031,401,182.00	1,263,238,461.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	588,717,500.00	817,560,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	588,717,500.00	817,560,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	442,683,682.00	445,678,361.12
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	323,018,182.00	407,974,311.12

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,479,100.00	37,704,050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,186,400.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,027,793,882.00	1,264,309,601.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,027,793,882.00	1,264,309,601.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,008,906,799.26	1,177,777,982.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,324,100.00	442,385,604.34
210101	Үндсэн цалин	74,928,300.00	331,322,234.06
210102	Нэмэгдэл	25,435,800.00	95,413,498.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,960,000.00	15,649,871.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,083,800.00	61,498,965.58
210201	Тэтгэврийн даатгал	9,910,800.00	40,099,920.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,043,300.00	4,468,165.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	834,600.00	8,027,576.34
210204	Ажилгүйдлийн даатгал	208,600.00	809,391.74
210205	Эрүүл мэндийн даатгал	2,086,500.00	8,093,911.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,815,200.00	20,073,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,637,100.00	4,936,800.00
210302	Түлш, халаалт	8,178,100.00	15,137,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,810,910.22	43,827,904.00
210401	Бичиг хэрэг	6,377,500.00	3,420,900.00
210402	Тээвэр, шатахуун	25,876,890.00	34,667,704.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,519,587.22	4,392,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,036,933.00	1,346,900.00
2105	Нормативт зардал	139,072,981.80	183,961,388.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,900,881.80	183,481,388.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	172,100.00	480,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,328,600.00	7,102,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,800,000.00	0.00
210604	Урсгал засвар	2,528,600.00	7,102,000.00
2107	Томилолт, зочны зардал	20,945,500.00	17,018,300.00
210702	Дотоод албан томилолт	20,945,500.00	17,018,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	666,387,807.24	401,774,160.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	663,824,384.24	389,536,779.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	409,562.00	573,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,570.00	357,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	319,000.00	341,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	921,291.00	165,561.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,900.00	135,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,900.00	135,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,887,082.74	86,531,619.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,879,600.00	3,660,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,877,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,002,400.00	3,660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,007,482.74	82,871,619.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,007,482.74	82,871,619.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,025,800.00	3,850,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,025,800.00	3,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,025,800.00	3,850,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,025,800.00	3,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,025,800.00	3,850,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,025,800.00	-3,850,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	257,526,384.45	257,526,384.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	257,526,384.45	257,526,384.45
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	426,170,353.05	426,170,353.05
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	683,696,737.50	683,696,737.50
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	683,696,737.50	683,696,737.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	683,696,737.50	683,696,737.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	1,909,092,601.48	1,909,092,601.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	817,560,100.00	739,609,620.92	77,950,479.08	90.47

21	УРСГАЛ ЗАРДАЛ	817,560,100.00	739,609,620.92	77,950,479.08	90.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	805,242,700.00	736,949,620.92	68,293,079.08	91.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	500,524,400.00	442,385,604.34	58,138,795.66	88.38
210101	Үндсэн цалин	369,565,400.00	331,322,234.06	38,243,165.94	89.65
210102	Нэмэгдэл	104,848,000.00	95,413,498.61	9,434,501.39	91.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,739,000.00	15,649,871.67	6,089,128.33	71.99
210104	Урамшуулал	4,372,000.00	0.00	4,372,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,460,700.00	61,498,965.58	9,961,734.42	86.06
210201	Тэтгэврийн даатгал	48,714,800.00	40,099,920.67	8,614,879.33	82.32
210202	Тэтгэмжийн даатгал	5,145,200.00	4,468,165.05	677,034.95	86.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,377,500.00	8,027,576.34	-1,650,076.34	125.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,029,000.00	809,391.74	219,608.26	78.66
210205	Эрүүл мэндийн даатгал	10,194,200.00	8,093,911.78	2,100,288.22	79.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,074,500.00	20,073,800.00	700.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,936,800.00	4,936,800.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	15,137,700.00	15,137,000.00	700.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,289,000.00	18,289,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	3,420,900.00	3,420,900.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	9,128,800.00	9,128,800.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,392,400.00	4,392,400.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,346,900.00	1,346,900.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	1,433,800.00	1,433,410.00	390.00	99.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	953,800.00	953,410.00	390.00	99.96
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,000.00	480,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,526,600.00	6,522,000.00	4,600.00	99.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,854,600.00	3,850,000.00	4,600.00	99.88
210604	Урсгал засвар	2,672,000.00	2,672,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	360,000.00	140,000.00	72.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	360,000.00	140,000.00	72.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	186,295,800.00	186,250,981.00	44,819.00	99.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,013,600.00	174,013,600.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000.00	0.00	2,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	573,100.00	573,100.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,500.00	357,720.00	42,780.00	89.32
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	341,000.00	341,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	165,600.00	165,561.00	39.00	99.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,900.00	135,860.00	2,040.00	98.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,900.00	135,860.00	2,040.00	98.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,317,400.00	2,660,000.00	9,657,400.00	21.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,317,400.00	2,660,000.00	9,657,400.00	21.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,655,500.00	0.00	9,655,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,661,900.00	2,660,000.00	1,900.00	99.93
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	817,560,100.00	822,481,240.00	-4,921,140.00	100.60
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	817,560,100.00	817,560,100.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	817,560,100.00	817,560,100.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	4,921,140.00	-4,921,140.00	-
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,921,140.00	-4,921,140.00	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	51.00	38.00	13.00	74.51
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	27.00	13.00	67.50
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	445,678,361.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,678,361.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	444,678,361.12

2104	Хангамж, бараа материалын зардал	25,538,904.00
210402	Тээвэр, шатахуун	25,538,904.00
2105	Нормативт зардал	182,527,978.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182,527,978.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,430,000.00
210604	Урсгал засвар	4,430,000.00
2107	Томилолт, зочны зардал	16,658,300.00
210702	Дотоод албан томилолт	16,658,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,523,179.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	215,523,179.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	445,678,361.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	445,678,361.12
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	407,974,311.12
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,704,050.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газар /цаашид Мал эмнэлгийн газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэх, төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэж, сар бүр олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

МЭЕГ-аас 2021 онд “Мал эмнэлгийн салбарын боловсон хүчний чадавхийг сайжруулах”, аймгаас “Чанарыг эрхэмлэх жил” болгож, тэдгээрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах,
- Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах,
- Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ХХААХҮС-ын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А-385 дугаар тушаалаар баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн тусгайлсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,201,209.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,018.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 13,513.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,225,552.1 мянган төгрөгөөр буюу 179.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа		7,200,000.00	7,200,000.00
Бараа материал	109,948,957.90	225,227,519.84	115,278,561.94
Үндсэн хөрөнгө	573,747,780.00	1,676,821,275.96	1,103,073,495.96
Нийт хөрөнгө	683,696,737.90	1,909,248,795.80	1,225,552,057.90
Өр төлбөр		156,194.32	156,194.32
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	683,696,737.90	1,909,092,601.48	1,225,395,863.58
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	683,696,737.90	1,909,248,795.80	1,225,552,057.90

Тайлант онд Даталанд Технологи ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төсвийн хяналтын нэгдсэн программын үйлчилгээний хөлс буюу 2022 оны төлбөрийг 12 сард төлсөн тул урьдчилж гарсан зардал 7,200.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 225,227.5 мянган төгрөг болж 115,278.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 221,711.9 мянган төгрөгийн материал худалдан авсан, МЭЕГ-аас 846,554.2 мянган төгрөгийн вакцин, эм боох материал, 40,585.8 мянган төгрөгийн ариутгалын бодис, маск, мананцаржуулагч, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 94,544.7 мянган төгрөгийн эм боох материал, аймгийн Онцгой комиссоос 279.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, ОБГ-аас 1,467.4 мянган төгрөгийн шатахууныг үнэ төлбөргүй хүлээн авч, 1,089,864.5 мянган төгрөгийн материал зарцуулсан зэргээс шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд он дамжсан, ашиглалтгүй хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,940,486.8 мянган төгрөг болж 1,003,223.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3,850.0 мянган төгрөгийн компьютер, принтер худалдан авсан, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 1,229,577.3 мянган төгрөгийн лабораторийн зориулалттай тоног төхөөрөмжүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан болон өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 45,638.1 мянган төгрөгөөр үнэлж орлого авч, аймгийн ИТХТ-ийн 2021 оны 122 дугаар тогтоолоор 47,632.4 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 228,210.0 мянган төгрөгийн хөрөнгийн дансны үнийг бууруулсан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд батлагдсан цахилгааны зардлын төсөв хүрээгүйгээс 156.2 мянган төгрөгийн гэрэл цахилгааны өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,909,092.6 мянган төгрөг болж 1,225,395.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,899,694.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 1,727,355.1 мянган төгрөгөөр өссөн болон улсын төсвөөс малын халдварт өвчин болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гэсэн 2 арга хэмжээнд 172,339.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон зэргээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,100,468.8 мянган төгрөгөөр 1.9 дахин өссөн нь тайлант онд малын халдварт өвчин болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинтай холбоотойгоор эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 701,480.4 мянган төгрөгөөр, тарилгын үйлчилгээний хөлс 172,339.2 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотойгоор элэгдлийн зардал 153,946.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 72,703.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 787,614.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 99,637.2 мянган төгрөгөөр бууруулж, 687,976.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж, 2021 оны 11-р сард 129,583.2 мянган төгрөгөөр өсгөн, 817,560.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь тайлант онд малын халдварт өвчин болон архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 817,560.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 817,560.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,921.1 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэн 739,609.6 мянган төгрөгийг зарцуулж, тайлант оны эцэст 82,871.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 4,921.1 мянган төгрөг нь үндсэн үйл ажиллагааны



3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тус газрын тайлант оны үйл ажиллагаанд 817,560.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 739,609.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 10 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,696.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, цаашид анхаарах, давтан гаргахгүй байх 2 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	1,696.1	1	1,696.1	100
Зөвлөмж	2		2		100
Нийт дүн	3	1,696.1	3	1,696.1	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,225.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2 зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 *Илрүүлэлт:* Тайлант онд 2,225.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

орлого, 68,100.5 мянган төгрөг нь орон тоо дутуу ажилласнаас үүссэн цалин болон ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэлийн зардал, 9,657.4 мянган төгрөг нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, 192.6 мянган төгрөг нь бусад зардлын хэмнэлт байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус Мал эмнэлгийн газар нь нэмэлт санхүүжилтийн дансанд УМЭАЦТЛ-оос малын тандалт шинжилгээний зардалд 15,489.7 мянган төгрөг, МЭЕГ-аас гахайн мялзан, шүлхийн вакцинжуулалтад 22,214.3 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас МЭУСАХЗ-ын 316,766.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс шүлхийн вакцинжуулалт болон ариутгал, халдваргүйжуулалтад 74,208.4 мянган төгрөг, Онцгой байдлын газраас шүлхийн вакцинжуулалтад 17,000.0 мянган төгрөг зэрэг нийт 445,678.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс: тээвэр шатахууны зардалд 25,538.9 мянган төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад 182,527.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4,430.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 16,658.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 215,523.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,000.0 мянган төгрөг зэрэг нийт 445,678.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

МЭЕГ нь 2021 оны 11-р сард тус газрын төсвийг тодотгохдоо мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд Даталанд Технологи ХХК-тай байгуулсан гэрээний дагуу МЭЕГ-ын хүрээнд ашиглагдах төсвийн хяналтын нэгдсэн программын 2022 оны төлбөрийг баталсан байна. Цаашид төсвийн зохицуулалтыг тухайн төсвийн жилд хамаарах зардлыг хамруулан хийж байх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. **Нэмэгдэл цалинтай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж бус оны эхэнд тушаал гаргаж, бүтэн жилийн турш олгож ирсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэж, сар бүр олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мал эмнэлгийн газар	2	2,225.3	-	-	-	-	-	-	2	2,225.3